

ШҮҮХИЙН НӨӨЦ, ТӨСӨВ ТӨЛӨВЛӨЛТ

Хуульч, судлаач Ж.Алтансүх

Нээлттэй Нийгэм Форум шүүх засаглал улс төр болон бусад нөлөөллөөс ангид, хуульд захирагдсан, олон нийтийн итгэлийг хүлээсэн тогтолцоо байхад бодлогын түвшинд дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд бодлогын судалгаа шинжилгээ, салбарын мэргэжилтнүүдийн дунд шүүмж, хэлэлцүүлэг зохион байгуулж ирлээ.

2025 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа дуусаж нээлттэй сонгон шалгаруулалт, томилгооны процесс эхэлсэнтэй холбоотой шүүхийн захиргааны хүрээнд өнгөрсөн 4 жилийн хугацаанд шүүмжлэл, сорилт дагуулсан асуудлуудаар бодлогын шинжилгээ, хэлэлцүүлэг хийх хэрэгцээ шаардлага үүссэн юм.

2025 оны 11 сарын 12-нд Монголын хуульчдын холбоотой хамтран “Шүүхийн захиргааны тулгамдсан асуудал” бодлогын хэлэлцүүлгийг шүүгчийн томилгоо болон шүүхийн төсөв, нөөцийн удирдлага гэсэн асуудалд төвлөрсөн байдлаар зохион байгууллаа. Шүүгчийн томилгооны асуудлаар Оюуны Инновац ТББ ННФ-ын санхүүжилтээр хийсэн судалгаагаа танилцуулсан бол Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн ТББ-ын судлаач Ж.Алтансүх шүүхийн төсвийн удирдлагын талаар шинжилгээ хийж танилцууллаа.

Бодлогын асуудлын энэ удаагийн дугаарт нь энэхүү хараат бус шинжилгээг бодлого боловсруулагчдад хүргэж, цаашид шүүхийн төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналттай холбоотой гүнзгийрүүлсэн судалгаа, хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Энэ дашрамд шүүхийн төсөв, нөөцийн удирдлагын сэдвээр сонирхож судлах судлаачид, бодлогын манлайлал үзүүлэх бодлого боловсруулагч, батлагч нарыг хамтран ажиллахыг урьж байна.

АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс 1992 оны Ардчилсан Үндсэн хуулиа баталснаар шүүхийг бие даан ажиллах боломж, нөхцөлөөр хангах мөн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаар ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Өнөөгийн эрх зүйн орчны хүрээнд

шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг Үндсэн хуулийн болон ердийн хуулиар шинээр тодорхойлон тогтоосон боловч Монгол Улсын Шүүхийн индекс судалгаагаар 2023 оны байдлаар шүүхийн эрх хэмжээ, бие даасан

байдал, Шүүхэд итгэх олон нийтийн итгэл, Шүүхийн дэд бүтэц гэсэн хэмжигдэхүүнүүд 1.29-4.77 оноогоор буурчээ.¹

Үүнд олон хүчин зүйлүүд нөлөөлсөн бөгөөд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс шүүхийн эдийн засгийн баталгааг дордуулах, ялангуяа шүүхийн төсвийг Хууль зүйн байнгын хороогоор хяналт хийхдээ төсвийг бууруулах, мөн Сангийн яамнаас төсвийг бууруулах ёстой гэсэн хандлага хэвээр байна.^{2,3} Мөн түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөл болон Улсын Дээд шүүх төсвөө тусдаа өргөн мэдүүлж байгаа нь Үндсэн хуульд тусгасан шүүхийн тогтолцоо нэгдмэл байх зарчимд харшилж болзошгүй. Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд шүүхийн төсвийг хуульд заасны дагуу өргөн мэдүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг шаардлагатай нь харагдлаа.

Иймд энэхүү товч шинжилгээгээр шүүхийн нөөц, төсөв төлөвлөлтийг төрөөс хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар товч мэдээлэл хүргэхийг зорилоо. Ийнхүү судлахдаа 1993, 2002, 2013, 2021 оны Шүүхийн тухай хуулиудад тус тус харьцуулалт хийж, цаашид хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн нөөц, төсөв төлөвлөлтийг хэрхэн сайжруулах талаарх санал дэвшүүлэх зорилготой болно.

Олон улсын туршлага, харьцуулалт

Дэлхийн ихэнх орнуудад хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс шүүхийн төсвийн хэмжээг хангалттай хэмжээнд батлахгүй, үндэслэлгүйгээр бууруулахаас сэргийлэх

талаар тодорхой зөвлөмжүүд гарсан байдаг. Энэ талаар Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай “Софигийн тунхаглал”-д:

“Засгийн газар, төсөв санхүүгийн аливаа зардлын хэмнэлт нь шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг сулруулж үл болно”, “Санхүүгийн тогтвортой байдал, ажлын байрны баталгаа, захиргааны бие даасан байдал нь бие даасан, хараат бус шүүхийн зайлшгүй хамгаалалт мөн”, “Шүүгчид улс төрийн маргаантай асуудлаар чимээгүй байх ёстой гэсэн уламжлалт хандлага шүүхийн бие даасан, хараат бус байдалд аюул заналхийлэл учирсан тохиолдолд үйлчлэх ёсгүй”, “Засгийн газраас хувь шүүгчид болон шүүхийн зөвлөлийн бие даасан, хараат бус байдалд халдах гэсэн аливаа саналын эсрэг тодорхой бөгөөд итгэлтэйгээр эсэргүүцлээ илэрхийлэх үүрэгтэй” гэжээ.⁴

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн “Шүүхийн хараат бус байдлын суурь зарчмууд” 40/32 дугаар тогтоолд шүүхийн болон шүүгчийн эдийн засгийн бие даасан байдлын үндсэн зарчмуудыг тусгаж, гишүүн орнуудад мөрдөхийг зөвлөсөн байдаг. 2002 онд Шүүхийн удирдах ажилтны Гаагийн уулзалтаар баталсан “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчим”, Ази, Номхон далайн улс орнуудын шүүгчдийн хамтын нийгэмлэгээс гаргасан “Шүүгчийн бие даасан байдлын үндсэн зарчмуудын тухай Бээжингийн Тунхаглал” зэрэг олон баримт бичгүүдэд шүүх, шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний эдийн засгийн баталгааг хангахад онцгойлон анхаарсан

¹ “Монгол Улсын Шүүхийн индекс,” accessed March 6, 2025, <https://judindex.forum.mn/general-point>

² Судлаачийн зүгээс 2025 оны 08 дугаар сарын 19-20-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн зарим гишүүдтэй хийсэн уулзалтаар Сангийн яамнаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийг бууруулах шаардлагатай гэсэн хандлага гаргаж байсан талаар дурдсан. Өөрөөр хэлбэл, Сангийн яамны зүгээс Төсвийн тухай хууль нь салбарын нарийвчилсан хууль учраас Төсвийн тухай хуулийг баримтлах нь зүйтэй гэж тайлбарладаг байна.

³ Түүнчлэн Монголын хуульчдын холбооны 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хэлэлцүүлэгт зарим хуульчид “... Сангийн сайд бусад төрийн захиргааны байгууллагын төвшинд шүүхийг авч үзэж тэдэнтэй адил шалгуураар шүүхийн төсвийг танана гэж үзэж байгаа нь Үндсэн хуулийн суурь зарчмын талаар ямар ч ойлголтгүйг харуулж байна.” гэх зэргээр шүүмжилж байв.

⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл, Хараат бус, хариуцлагатай шүүхийн тогтолцооны талаарх “Софигийн тунхаглал”, “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, УБ., 2015, дугаар 4, 54.

байна.⁵ Дээрхээс үзэхэд дэлхийн улс орнуудад шүүхийн төсвийг бууруулахгүй байх асуудлаар онцгойлон анхаардаг болохыг харуулж байна.

Түүнчлэн дэлхийн улс орнуудад шүүхийн төсвийн саналыг боловсруулах, өргөн барих гурван гол загварыг баримталдаг байна. Үүнд:

- 1/ Тэгд суурилсан төсөвлөлт (Zero-based): Энэ хэлбэр нь шүүх тус бүр ирэх жилийн төсвөө шинээр төсөвлөж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн батлуулдаг онцлогтой.
- 2/ Аажмаар өсөх төсөвлөлт нь тухайн жилийн төсөв нь өмнөх жилийн төсөвт үндэслэх шинжтэй төсөвлөлтийн хэлбэр бөгөөд эдийн засаг султай улс орнуудад илүү зохицдог.
- 3/ Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт: Энэ хэлбэр нь шүүхийн үйл ажиллагааны үр дүнгийн хэмжүүрээр илэрхийлсэн үзүүлэлтүүдэд үндэслэн суурь төсөв болон төсвийн тодотголыг боловсруулдаг онцлогтой. Нидерланд, Дани, Франц, ИБУИНВУ болон АНУ-ын зарим муж улсуудад энэ байдлаар шүүхийн санхүүжилтийг шийдвэрлэдэг байна.⁶

Монгол Улсын хувьд 1993-2021 он хүртэл эхнийх буюу ирэх жилийн төсвөө шинээр төсөвлөж, төсвийн саналаа хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлж байсан боловч 2021 оноос хойш Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүхийн төсвийн хэмжээг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно гэж тусгаснаар аажмаар өсөх төлөвлөлт бүхий загварыг хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд Швейцар, Финланд, Өмнөд Африк⁷, Швед, Унгар зэрэг улсын туршлагаар шүүхийн зөвлөл шүүхийн төсвийг боловсруулж

хууль тогтоох байгууллагад шууд өргөн барьдаг зохицуулалтыг авч хуульдаа тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал

Энэхүү товч шинжилгээгээр Монгол улсад шүүхийн байгууллагын эдийн засгийн баталгааг хангахад үйлчилж байсан болон одоо үйлчилж буй эрх зүйн орчныг түүхчлэн авч үзлээ. Ийнхүү судалж үзвэл шүүхийн төсөв нэгдмэл байх зарчим; шүүхийн төсөв төлөвлөлт, батлуулах, байнгын хороогоор хянуулах ажиллагаа; шүүхийн төсвийг гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд нэвтрүүлэх асуудал; шүүхийн дэд бүтэц, хөрөнгө оруулалт; шүүгчийн ажлын ачааллын тэнцвэртэй байдал; шүүгчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулах зэрэг асуудлаар хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас цаашид анхаарал хандуулах шаардлага гарч байна гэж үзлээ. Ингээд судалгааны үр дүнг Шүүхийн тухай хууль батлагдсан он цагийн дарааллаар товч танилцуулъя.

1993-2002 он

1993 онд “Монгол Улсын Шүүхийн тухай” болон “Шүүх байгуулах тухай хууль”-ийг анх баталсан. Эдгээр хууль батлагдсанаар өмнө үйлчилж байсан шүүхийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, шүүх бие даан ажиллах, шүүгч хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн үндэс тавигджээ. Дээр дурдсан хуулиудын хүрээнд шүүхийн тогтолцоо а/ Улсын Дээд шүүх (цаашид “УДШ” гэх), б/ аймаг, нийслэлийн шүүх, в/ сум болон сум, дүүрэг буюу дүүргийн шүүх гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй

⁵ О.Мөнхбат, О.Мөнхсайхан, Шүүгчийн цалин, хангамжийг тогтоох, үндэслэл, шаардлага (УБ: Шүүхийн ерөнхий зөвлөл, 2013).

⁶ Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал (Харьцуулсан судалгаа), Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл, 38.

⁷ Шүүхийн судалгаа, мэдээллийн төв, “Шүүхийн төсвийг батлах: шүүхийн хараат бус байдлыг хамгаалах (лавлагаа)” (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2013), 4–5, <http://resource3.sodonvision.com/shuuh/file/2014/4/121ftuvycs1mfghi0s4wup5dh/Шүүхийн%20төсөв,%20хараат%20бүс%20байдал.pdf>.

болсон.⁸

Үндсэн хуульд тусгаснаар “Шүүх улсын төсвөөс санхүүжиж, шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэж заасны дагуу 1992 оноос шүүхийн тогтолцоог бүхэлд нь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх зарчим, журам тогтож, анхан болон давж заалдах шатны шүүхийн төсөв орон нутгийн төсвөөс хамаарахгүй болсон байна. Шүүхийн төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж ирсэн тогтолцоог халж, улсын нэгдсэн төсвөөс санхүүжүүлэх болсон нь шинэлэг зохицуулалт байв.⁹

1993 оны Шүүхийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 1-д “Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана”. Мөн зүйлийн 2-т “Шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгана. Шүүхийн төсөв шүүх эрх мэдлийг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байвал зохино” гэсэн зохицуулалтыг шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны хуулийн 2 дугаар зүйлд ... Шүүхийн тухай 1993 оны хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т “Шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгана. Шүүхийн төсөв нь Улсын дээд шүүхийн төсөв, орон нутгийн шүүхийн ба дагнасан шүүхийн төсөв, Ерөнхий зөвлөлийн төсвөөс бүрдэх бөгөөд тэдгээрийг Улсын Их Хурал тус, тусад нь батална. Шүүхийн төсөв нь шүүх эрх мэдлийг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байвал зохино” гэж өөрчлөн найруулсан.¹⁰ Ийнхүү шүүхийн

төсвийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах процесс 1996 оноос хойш өнөөг хүртэл УДШ болон бусад шүүхийн гэсэн ялгамжтай байдлаар батлах журам хэрэгжиж эхэлжээ.

Энэ талаар судлаачид шүүмжлэлтэй хандаж “Шүүхийн төсвийг Шүүхийн ерөнхий зөвлөл болон анхан болон давж заалдах шатны шүүхийн, Улсын дээд шүүхийн гэж хоёр тусад нь боловсруулан батлах зохицуулалт өнөөг хүртэл үйлчилж байгаа нь Үндсэн хуулиар Улсын дээд шүүхийг шүүхийн тогтолцооны салшгүй хэсэг гэдгийг тодорхой заасан атал төсвийг нь зориуд салгаж буй нь шүүхийн нэгдмэл байдлыг сулруулах, эдийн засгийн нөлөөлөл тогтоож байгаа үйлдэл”¹¹ гэж үзэж байв. Түүнчлэн Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1-т Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. Мөн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-т Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно гэсэн суурь зарчмын хэрэгжилтийг шүүхийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэхгүй байгаагийн илрэл гэжээ.¹²

Ингээд 1993-2002 оны хооронд шүүхийн эдийн засгийн баталгаа хэрхэн хангагдаж байсан талаар дор авч үзье.

Шүүх нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэхэд хяналт тавьж, хэрэв хуульд нийцээгүй бол тухайн шийдвэрийг хүчингүй болгодог. Үүгээрээ зарим

⁸ С.Жанцан, Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын тогтолцоо, /УБ, 2005/, 63.

⁹ Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал (Харьцуулсан судалгаа) (Улаанбаатар хот: Шүүхийн ерөнхий зөвлөл, 2023), 9.

¹⁰ Шүүхийн тухай хууль, 1993 он, 60 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=7167>

¹¹ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль, шинжлэх ухааны тайлбар, 2nd ed. (Улаанбаатар хот: Адмон принт, 2024), 813.

¹² Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал (Харьцуулсан судалгаа), 9.

талаар хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс шүүхэд дарамт шахалт үзүүлэх, шүүхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэхээс татгалзах үйлдэл хийхэд

хүргэдэг.¹³ Гэвч Монгол Улсын хувьд 1993-2002 оны хооронд шүүхийн төсвийн улсын төсөвт эзлэх хувь ойролцоогоор 0.30-0.46 орчим хувьтай хэлбэлзэж иржээ.¹⁴

Хүснэгт 1. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь (1994-2002 он)¹⁵

Төсвийн жил	Улсын төсөв (Мянган төгрөг)	Шүүхийн төсөв (Мянган төгрөг)	Улсын төсөвт эзлэх хувь хэмжээ
1994	78,468,137.7	238,638.4	0.30
1995	132,153,100.0	555,040.5	0.42
1996	162,377,500.0	587,124.0	0.36
1997	151,867,974.3	718,287.1	0.47
1998	293,963,978.6	1,047,741.1	0.36
1999	338,846,397.0	1,071,135.6	0.32
2000	391,588,620.1	1,547,518.0	0.40
2001	440,157,875.0	1,760,631.5	0.40
2002	435,691,020.2	1,994,593.8	0.46

Энэхүү тоон мэдээллээс үзэхэд Шүүхийн тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд 1993-2002 онд улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь дунджаар 0.39 хувь байжээ. Энэ нь тухайн үеийн нийгэм, эдийн засгийн шилжилтийн “хүнд” үеийг хамарч байсан бөгөөд эдийн засгийн хувьд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс хараат байдалд орсон байв. Тухайлбал, 1994-2002 онуудын хооронд шүүхийн төсөв хүрэлцэхгүй буюу 36.2-49.5 сая төгрөгийн өртэй, шүүгчийн цалин хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар шүүгчийн орон тоог хассан /2003 онд шүүхийн төсвийг 15 хувиар хасаж, шүүхийн 79 ажилтны орон тоог цомхотгосон асуудал гарсан/ түүнчлэн шүүхийн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсэг болох орон байр /Төв аймгийн шүүх банкны байранд түрээсээр үйл ажиллагаа явуулдаг/, машин тэрэгний дутагдалтай /Сум дундын 2 шүүх дундаа нэг УАЗ 469 машинтай/ зэрэг асуудлууд гарч байсан.¹⁶ Үүнд судлаачид

шүүмжлэлтэй хандаж шүүхийн төсвийн доод хэмжээний хувийг тогтоож Улсын нэгдсэн төсвийн ядаж нэг хувьд хүргэх шаардлагатай гэж шүүмжилж байв.

2002-2013 он

Шүүхийн тухай 2002 оны хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Шүүхийн төсөв нь Улсын Дээд шүүхийн төсөв, орон нутгийн шүүхийн болон дагнасан шүүхийн төсөв, Ерөнхий зөвлөлийн төсвөөс бүрдэнэ”, 62 дугаар зүйлийн 62.1.3-т шүүхийн төсвийг хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих бүрэн эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд үлдээж, шүүхийн төсвийн төслийг өргөн барих бүрэн эрхийг хасаж уг чиг үүргийг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай 2002 оны хуулиар зохицуулжээ. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7-д Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шүүхийн төсвийн; 11.1.8-д Шүүхийн

¹³ ХЗҮХ, “Монгол Улсын Шүүхийн Тухай Хуулийн Хэрэгжилтийн Үр Дагаврыг Үнэлэх Үнэлгээ,” Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн, 2018, 20, <https://www.academia.edu>.

¹⁴ Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал (Харьцуулсан судалгаа), 10. (дам эшлэв)

¹⁵ Мөн тэнд.

¹⁶ Б.Чимид, Үндсэн Хуулийн Үзэл Баримтлал: Хүний Эрх, Шүүх Эрх Мэдэл, 2 Дугаар Дэвтэр (Улаанбаатар хот: Чимид сан, 2004), 146–49.

ерөнхий зөвлөлийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн төсвийн; мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн төслийг

нэгтгэн ... Засгийн газарт мэдүүлнэ. Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т Засгийн газар төсвийн төслийг ерөнхийлөн захирагч бүрээр хэлэлцэнэ гэж тусгажээ.¹⁷ Ингээд Монгол Улс дахь шүүхийн төсвийн эзлэх хувь хэмжээ хэрхэн хэрэгжиж байсныг 2002-2013 оны байдлаар харуулъя.

Хүснэгт 2. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь (2003-2012 он)¹⁸

Төсвийн жил	Улсын төсөв (Мянган төгрөг)	Шүүхийн төсөв (Мянган төгрөг)	Улсын төсөвт эзлэх хувь хэмжээ
2003	558,198,728	2,201,713	0.39
2004	699,102,676	2,701,279	0.39
2005	775,069,573	3,360,534	0.43
2006	1,161,197,115	4,141,438	0.36
2007	1,725,971,669	7,293,628	0.42
2008	1,815,584,400	13,283,100	0.73
2009	1,854,741,100	9,819,300	0.53
2010	2,423,103,400	12,113,500	0.50
2011	3,609,784,500	14,309,100	0.40
2012	4,865,904,200	20,876,000	0.43

Энэхүү тоон мэдээллээс үзэхэд 2003-2012 оны хооронд дунджаар улсын төсвийн 0.46 хувийг эзэлсэн байна. Үүнээс 2008 оны улсын төсөвт хамгийн өндөр буюу 0.73 хувийг, харин 2006 онд хамгийн бага буюу 0.36 хувийг эзэлсэн байна. Үүнийг Монгол дахь засаглалын төлөв байдлыг үнэлэх судалгаа (2006 он) судалгаанд шүүхийн төсвийг улсын төсөвт 0.45 хувь орчимд тооцон олгож байгаа нь шүүх, шүүгчийн орон байр,

цалин, томилолт, холбоо харилцаа, шүүн таслах ажиллагаанд хүрэлцдэггүй зэрэг нь шүүхийг улс төрөөс зарим талаар хараат болгож байна гэж дурджээ.

Үүнээс үзвэл 2002-2013 оны хооронд Шүүхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн боловч өмнө нь үүсэж байсан тулгамдсан асуудлыг шийдвэрлээгүй, шүүхийн төсвийн хэмжээ мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй байна.

2013-2021 он

“Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”, “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийн тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж болон “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийг

хэрэгжүүлэх ажлын хүрээнд шүүхийн тухай багц 6 хуулийг 2013 онд баталсан. Эдгээр хуулиудыг дурдвал 1/ Монгол Улсын Шүүхийн тухай хууль; 2/ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль; 3/ Хуульчийн эрх зүйн байдлын тухай; 4/ Шүүхийн захиргааны тухай хууль;

¹⁷ Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал (Харьцуулсан судалгаа), 11.

¹⁸ Мөн тэнд, 11.

5/ Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай; 6/ Эвлэрүүлэн зуучлалын тухай юм.

Эдгээр хуулиуд батлагдсанаар шүүх, шүүгч, хуульч, шүүхийн захиргаа, шүүхийн иргэдийн төлөөлөгч, эвлэрүүлэн зуучлалын талаарх зохицуулалтыг цогцоор авч үзэж, шинээр хуульчилснаараа онцлогтой болсон. Дээрх

хуулиуд батлагдсанаар шүүхийн бие даасан байдал тэр дундаа шүүхийн эдийн засгийн баталгаа хангагдахад өмнөх жилүүдтэй харьцуулахад тодорхой ахиц дэвшил гарсан талаар судлаачид үнэлжээ.¹⁹ Ингээд шүүхийн төсвийн хэмжээг 2013-2021 оны байдлаар дор хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 3. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь (2013-2021 он)²⁰

Төсвийн жил	Улсын төсөв (Мянган төгрөг)	Шүүхийн төсөв (Мянган төгрөг)	Улсын төсөвт эзлэх хувь хэмжээ
2013	5,165,568.70	48,339.90	0.936%
2014	5,631,357.10	61,914.50	1.099%
2015	5,218,529.60	56,013.60	1.073%
2016	7,749,656.30	51,680.40	0.67%
2017	7,420,601.40	50,814.40	0.685%
2018	7,710,777.60	52,602.90	0.682%
2019	9,406,581.70	61,039.80	0.649%
2020	11,653,262.00	61,039.20	0.524%
2021	12,568,721.80	66,389.00	0.528%

Энэхүү тоон мэдээллээс үзэхэд шүүхийн тухай багц хууль батлагдсантай холбогдуулан 2013-2015 оны хооронд улсын төсөвт эзлэх шүүхийн төсвийн хэмжээ 0.93-1.099 хувь болон нэмэгдсэн боловч 2016-2021 оны хооронд шүүхийн төсвийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Энэ нь 2012 онд батлагдсан ШЭЗБТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй", ШТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.5-д заасан "шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно" гэж

тусгасныг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсонтой холбоотой.²¹

Үүний дараа хууль тогтоогч Үндсэн хуулийн цэцээс Шүүх байгуулах тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болгосон (тойргийн шүүх байгуулах асуудал), ШЕЗ-өөс шүүгчийн сонгон шалгаруулалтад үзэмжээр хандсан, Ерөнхийлөгчөөс нэр бүхий зарим шүүгчийг шүүгчээр буцаан томилоогүй, Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн чиг үүргийг задлах, мөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Шүүхийн сахилгын хороог

¹⁹ ХЗҮХ, "Шүүхийн Шинэтгэлийн Хэрэгжилт, Үр Дүн, Цаашдын Асуудал," 62.

²⁰ Монгол Улсын 2013-2021 оны төсвийн тухай хууль. Төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч (УДШ болон ШЕЗ-ийн төсвийг нэгтгэсэн дүнгээр)-ийн Улсын төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээнд харьцуулав. <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=27&useq=%D0%BC&page=2&active=1&sort=title&page=1>

²¹ Иргэн Ж.Алтансүхийн "Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулиар ШЭЗБТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, ШТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосон" нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэлээр гаргасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан. Улмаар давж заалдах гомдлыг гаргасан боловч 2017 оны 1 сарын 25-ны өдрийн бага суудлын хуралдаанаар гомдлыг Т.Лхагваа, Д.Сугар, Д.Одбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоол, дугаар 178, 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр.

Үндсэн хуулийн цэцийн магадлал, дугаар 6, 2017 оны 1 сарын 25-ны өдөр.

байгуулсан, УИХ-аас ШТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.5, ШЭЗБТХ-ийн 23.5-д тусгасан эдийн засгийн баталгааг дордуулсан зэрэг олон асуудлыг эрх зүйн хувьд шинээр авч үзэх шаардлагатай гэж үзэж Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 онд баталжээ.

2021 оноос хойш

1993 онд Шүүхийн тухай хууль батлагдсанаас хойш шүүхийн тогтолцоог үр ашигтай зохион байгуулахад анхаарч ирсэн ч сүүлийн жилүүдэд нэг шүүгчид ногдох хэргийн тоо нийслэл хот болон орон нутагт тэнцвэртэй бус, харилцан адилгүй байдал үүссэн. Энэ асуудлаас үүдэн шүүгчдийн ачаалал тэнцвэргүй, шүүхийн үйлчилгээ хүртээмжгүй, чанаргүй, цаашлаад иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх зөрчигдөхөд хүрсэн. Улмаар шүүхийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй, шүүхийн шийдвэрийг чанаржуулах, оновчтой шийдэл нь шүүхийг тойргийн зарчмаар байгуулах, шүүхэд дагнасан тогтолцоог нэвтрүүлэх явдал гэж

судлаачид онцолсон байна.²²

Энэ үүднээс 2019 оны Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Ийнхүү Үндсэн хуульд тусгаснаар Шүүхийн тогтолцоог шинээр тодорхойлох, ШЕЗ-ийн бүрэн эрх, чиг үүрэгт өөрчлөлт орсон, Шүүхийн сахилгын хороог шинээр зохион байгуулах гэх мэт эрх зүйн суурь шинжтэй өөрчлөлтийн улмаас Монгол Улсын Шүүхийн тухай хууль батлагдсан. Тус хууль батлагдсанаас хойших шүүхийн төсвийн хэмжээг дор хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 4. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь (2022-2025)

Төсвийн жил	Улсын төсөв (Мянган төгрөг)	Шүүхийн төсөв (Мянган төгрөг)	Улсын төсөвт эзлэх хувь хэмжээ
2022	11,599,233.6	89,169.10	0.769%
2023	16,949,914.60	105,997.60	0.625%
2024	22,677,835.30	200,223.70	0.883%
2025	24,209,847.50	361,658.00	1.494%

Энэхүү хүснэгтээс үзвэл 2021 онд батлагдсан Улсын Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь хэмжээ жил дараалан өссөн нь харагдаж байна. Энэ нь өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй дэвшилттэй байсан боловч 2022-2024 онд улсын төсөвт эзлэх хувь хэмжээ өнөөг хүртэл 1 хувьд хүрээгүй, мөн 2025 онд Шүүхийг тойргийн журмаар өөрчлөх,

Дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны шүүх, Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүхийг шинээр байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын болон урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Гэвч хуулийн энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл гарч, Хууль зүйн байнгын хороон дээр төсвийг бууруулах асуудал гарсаар

²² О.Алтантуяа нар, Монгол Улсын Үндсэн Хуульд 2019 Онд Оруулсан Нэмэлт, Өөрчлөлтүүдийн Дүн Шинжилгээ, 160.

байна. Тухайлбал, ШЕЗ-ийн 2024 оны төсийн хувьд төсвийн төслийн саналыг 204,595,725.0 мянган төгрөгөөр өмнөх оны төсвийн төслийн саналаас нэмж хүргүүлсэн. Гэвч хянасан төсвийн зардал нь төсвийн төслийн саналаас 19,852,929.5 мянган төгрөгөөр буюу 10,7 хувиар бууруулан хянагдсан дүнтэй байна.²³ Иймээс Сангийн яам болон холбогдох байнгын хороо төсвийн саналыг үндэслэлгүйгээр бууруулахаас сэргийлэхийн тулд олон нийтэд тайлбар, мэдээлэл гаргах, мөн ШЕЗ-ийн боловсруулсан төсвийн саналыг Хууль зүйн байнгын хороонд бууруулсан саналтай хамтад нь УИХ-д өргөн мэдүүлэх зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах нь зүйтэй.

Ингээд шүүхийн нөөц, төсөв төлөвлөлт холбоотой өнөөгийн тулгамдсан асуудлын талаар товч хүргэе.

Асуудал 1. Шүүхийн төсөв нэгдмэл байх зарчим

1996 оны Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд ... Шүүхийн тухай 1993 оны хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т “Шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгана. Шүүхийн төсөв нь **Улсын дээд шүүхийн төсөв, орон нутгийн шүүхийн ба дагнасан шүүхийн төсөв, Ерөнхий зөвлөлийн төсвөөс бүрдэх бөгөөд тэдгээрийг Улсын Их Хурал тус, тусад нь батална. Шүүхийн төсөв нь шүүх эрх мэдлийг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байвал зохино**” гэж өөрчилснөөс хойш шүүхийн төсвийн саналыг ШЕЗ болон УДШ тусдаа боловсруулан батлах практик тогтсон. Үүнийг одоогийн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46.8.1-д “Улсын Дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын Дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны

болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх” гэж хуульчилсан нь Монгол Улсад шүүхийн тогтолцоо нэгдмэл байх гэсэн зарчимтай харшилж байна.

Асуудал 2. Төсөв төлөвлөлт, батлуулах, байнгын хороогоор хянуулах ажиллагаа

Шүүхийн төсвийн саналыг боловсруулах, өргөн барих ажиллагааны процедурыг Шүүхийн тухай 2021 оны хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.1-д Улсын Дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын Дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх; 46.8.2-т Улсын Дээд шүүх, Ерөнхий зөвлөл Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх; 46.8.3-т Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 46.8.4-т Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Улсын дээд шүүх болон Ерөнхий зөвлөлийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх гэж хуульчлан тогтоосон.

Гэвч шүүхийн төсөв төлөвлөлт, батлуулах, байнгын хороогоор хянуулах үйл явцад төсвийн ерөнхийлөн захирагч ойр ойрхон солигдохтой холбоотойгоор төсөв боловсруулах, батлах явцад хүндрэл үүсч болзошгүй байна. Тухайлбал, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д Ерөнхий зөвлөл орон тооны 10 гишүүнээс бүрдэх бөгөөд дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана гэжээ. Үүнийг тодруулбал, тус хуулийн 76.4-

²³ Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал (Харьцуулсан судалгаа), 24.

д зааснаар Ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно гэж хуульчилснаар төсвийн ерөнхийлөн захирагч ойр, ойрхон солигдох явдал гарч байна. Энэ нь ШЕЗ-ийн төсвийн төлөвлөлт, батлуулах явц, байнгын хороогоор хянуулах ажиллагаа хуулиар тогтсон ажиллагаа гэхээс илүүтэйгээр хүнээс хамаарах эрсдэлтэй байна. Иймээс ШЕЗ-ийн дарга, төсвийн асуудал хариуцсан албан хаагч, мэргэжилтний тогтвортой ажиллах эрх зүйн орчныг хангах хэрэгтэй байна.

Асуудал 3. Шүүхийн төсвийг гүйцэтгэл суурилсан тогтолцоонд нэвтрүүлэх

Төсвийн тухай хууль (2022.11.11)-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/4 дүгээр зүйлийн 4.1.56 дахь заалтын 4.1.56-д “гүйцэтгэлд суурилсан санхүүжилт” гэж хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, төрийн үйлчилгээний чанар зэрэг гарцын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийг нийт дүнгээр нь төлөвлөж, хуваарилах” гэж тусгасан.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр төсвийг төсвийн ерөнхийлөн захирагчийн ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээнд суурилсан байдлаар төсөвлөх эрх зүйн орчин бий бүрдсэн бөгөөд цаашид шүүхийн төсвийг гүйцэтгэлд суурилсан шүүхийн санхүүжилт олгох талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой юм. Тухайлбал, судалгааны өмнөх хэсэгт дурдсан зарим орны туршлагаар шүүхийн хэрэг, маргааны тоо, ажлын ачаалал өмнөх жилээс нэмэгдэх зэрэг шийдвэрлэсэн хэргийн тоогоор шүүхийн төсвийг гүйцэтгэлд суурилан төлөвлөн тооцоолох жишиг байгааг судлах нь зүйтэй.

Асуудал 4. Шүүхийн дэд бүтэц, хөрөнгө оруулалт

ШЕЗ-ийн гаргасан тайлан, мэдээллээ өнөөгийн байдлаар Монгол Улсад түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа шүүх-7, Прокурорын байгууллагуудтай нэг байранд үйл ажиллагаагаа явуулж буй шүүх-7 байна. Түүнчлэн Монгол Улсын шүүхийн байрны өнөөгийн нөхцөл байдал судалгаа /2022/-нд дурдсанаар ШЕЗ-ийн 2014 оны 100 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн байрны нийтлэг шаардлагад шүүгч, ерөнхий шүүгчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээг ерөнхий шүүгчийн өрөө 24 ба түүнээс дээш, шүүгчийн өрөө 18 ба түүнээс дээш м.кв байхаар тогтоож өгсөн. Гэвч 1 шүүгчид 16.9 м.кв ноогдож байх ба 1 шүүгчид ноогдох талбайн хэмжээ Нийслэлд 18.7 м.кв байгаа бол орон нутагт 15.5 м.кв байна гэжээ. Үүнээс үүдэн шүүгчийн өрөөний талбайн хэмжээ нийслэлд нийтлэг шаардлагад хүрч буй бол орон нутагт 2.5 м.кв-аар бага байна.

Иймээс Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар “Шүүхийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг дэмжих сан”-г шинээр байгуулах боломжтой. Уг сангийн санхүүжилтийг улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн тусгай архивын үйлчилгээ гэх мэт шүүхийн үйлчилгээнээс олсон орлогоор санхүүжүүлэх нь зүйтэй. /2024 онд 20 тэрбум төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн байна/. Өөрөөр хэлбэл, Нидерланд, Финланд, Франц зэрэг улсад шүүхийн тухайн жилийн давсан орлого болон бусад орлогыг төвлөрүүлэх тусгай санг байгуулсан туршлагатай байна.

Асуудал 5. Шүүгчийн ажлын ачааллын тэнцвэртэй байдал

Өнөөгийн байдлаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх 2024 онд 1218 хэргийг 18.6 шүүгч шийдсэн бөгөөд 1 шүүгч дунджаар 65 хэрэг шийдвэрлэсэн, Аймгууд дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх 2024 онд 1 шүүгч дунджаар 25 хэрэг шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 50197 хэргийг 80 шүүгч шийдвэрлэсэн бөгөөд энэ нь нийт иргэний хэрэг маргааны 68.1 хувь байгаа Сонгино хайрхан дүүргийн анхан шатны шүүхэд 1 шүүгчид 740 хэрэг ноогдож байна. Үүнээс үзвэл хөдөө орон нутаг болон Нийслэл дэх шүүгч нарын ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна. Иймээс давж заалдах шатны шүүхийг тойргийн журмаар байгуулах замаар шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх талаар судлах шаардлагатай.

Асуудал 6. Шүүгчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулах

Сүүлийн жилүүдэд шүүгчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулах асуудал тулгамдсан асуудал хэвээр байна. Тухайлбал, Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр Монгол Улсын хэмжээнд инфляцын түвшин тогтмол 9-өөс дээш хувьтай байгаа нь шүүгчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

2012 онд батлагдсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэж байна” гэж тусгагдсан байсан боловч энэхүү заалтыг 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуульд тусгаагүй орхигдуулсан байна. Иймээс энэхүү заалтыг агуулгын хувьд дахин сэргээн хуульчлах шаардлагатай.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангахад улс төр, эдийн засаг, хууль зүйн олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд сүүлийн жилүүдэд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын зүгээс эдийн засгийн баталгааг сулруулах явдал удаа дараа гарч байсан. Энэ талаар судлаачид тухай бүр судалгааны тайлан, хийж байсан боловч өнөөг хүртэл энэ асуудал зарим талаар шийдэгдээгүй хэвээр байна. Иймээс энэхүү судалгаатай холбоотойгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Шүүхийн төсвийг гүйцэтгэлд суурилсан шүүхийн санхүүжилт олгох талаар судлах. Тухайлбал, шүүхийн хэрэг, маргааны тоо, ажлын ачаалал өмнөх жилээс нэмэгдэх зэрэг шийдвэрлэсэн хэргийн тоогоор шүүхийн төсвийг тооцоолох;

- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Шүүхийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг дэмжих санг шинээр байгуулах. Энэхүү санг улсын тэмдэгтийн хураамж болон шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлогоос санхүүжүүлэх;
- Шүүхийг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх (цаасан суурьтай хавтаст хэргийг цахим хавтаст хэрэгт нэвтрүүлэх, шүүхийн захиргааны ажилтны ажлыг хөнгөвчлөх чиглэлээр цахимжилтыг нэвтрүүлэх);
- Нийслэл болон орон нутгийн шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх талаар судлах гэх мэт хамаарна.



Хуульч, судлаач Ж.Алтансүх

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалавр, Хууль зүйн магистр зэрэгтэй. Тэрээр Үндсэн хуулийн болон шүүх эрх мэдлийн чиглэлээр 20 гаруй судалгаа хийсэн туршлагатай.